



**“ГАЗАР СҮЛЖМЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 09 дугаар
сарын 14-ны өдөр

Дугаар 06/01

Улаанбаатар
хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж
шинэчилсэн дүрэм батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15, Компанийн дүрмийн 7.1-р зүйл, “Газар сүлжмэл” ХК-ийн 2016 оны 09 сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсныг тогтоон “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.


- 1.1 “Газар сүлжмэл” ХК-ийн оноосон нэрийг татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан “Жуулчин Дюти Фрий” ХК болгох
- 1.2 Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар, Хан уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таванбогд Группийн төв байр Утас:345224, Факс:345223 болгон өөрчилөх,
- 1.3 Бөөний худалдаа эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг нэмэх

2. Компанийн дүрмийн өөрчлөлт бүхий шинэчилсэн найруулгыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Оргилболд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БААТАРСАЙХАН



**“ГАЗАР СҮЛЖМЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 09 дугаар
сарын 14 -ны өдөр

Дугаар 06/03

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг
шинээр сонгож, батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15, Компанийн дүрмийн 7.1-р зүйл, “Газар сүлжмэл” ХК-ийн 2016 оны 09 сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.7, 77 дугаар зүйлийн 77.1 хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдэд

1. Ц.Баатарсайхан
2. Д. Хулан
3. Ч.Ванчин-Эрдэнэ
4. Ц.Оюунцэцэг
5. Ц.Цэцэнхүү
6. Ц.Оргилболд


Хараат бус гишүүдэд

1. Ч.Пүрэвээ
2. Д.Байгальмаа
3. Ж.Мягмарсүрэн нарыг тус тус сонгогдсоныг баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд нь гишүүний үүргээ хууль болон компанийн дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлэх, компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: Ц.БААТАРСАЙХАН.





**“ГАЗАР СҮЛЖМЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 09 дугаар
сарын 14-ны өдөр

Дугаар 06/02

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь
өмнө дуусгавар болгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15, Компанийн дүрмийн 7.1-р зүйл, “Газар сүлжмэл” ХК-ийн 2016 оны 09 сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77-р зүйлийн 77 дугаар зүйлийн 77.3 дах хэсгийг үндэслэн “Газар сүлжмэл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд болох Д.Батжаргал, Б.Удаанжаргал, Н.Баасанхүү, Д.Уранчимэг, Ж.Долгормаа, Л.Батбаяр, Хараат бус гишүүд болох А.Буяннэмэх, А.Батцэцэг, М.Батбаяр нарын бүрэн эрх 2016 оны 09 сарын 14-ны өдрөөр хугацааны өмнө дуусгавар болгохыг тогтоосугай.

2. Энэхүү тогтоолыг төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх нь дуусгавар болж буй хувь хүмүүст танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ц.Оргилболдод үүрэг болгосугай

ХУРЛЫН ДАРГА



Д.БААТАРСАЙХАН